АВЛИГЫН ЭСРЭГ ХАМТДАА ХӨГЖИЛ, ЭНХ ТАЙВАН БА АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТӨЛӨӨ

UNITED AGAINST CORRUPTION

Хүмүүс ихэвчлэн авлигыг энгийн үзэгдэл гэж хүлээн зөвшөөрч, эвлэрсэн байдаг бөгөөд амьдралын нэг хэсэг, хэв маяг гэж үздэг. Гэвч авлигын эсрэг нэгдэж хамтдаа тэмцвэл энэ нь улс орон, нийгэм, олон нийтэд ашиг тустай байх болно. Та бүхэн авлигаас урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх дараах зөвлөмжтэй танилцана уу:

БОДЛОГО ТОДОРХОЙЛОГЧИД БОЛОН ТӨРИЙН АЛБАН ХААГЧИД дараах байдлаар авлигатай тэмцэх боломжтой

Ардчиллыг бэхжүүлэх...

Авлигын Эсрэг НҮБ-ын Конвенцид нэгдэн орох, соёрхон баталж хэрэгжүүлэх
Авлигын эсрэг амжилттай тэмцэж, чанга хатуу арга хэмжээ авч чаддаг улс оронд ард иргэдийн итгэлийг авахын зэрэгцээ тогтвортой байдлыг хангаж чаддаг.

Шударга ёсыг бэхжүүлэх...

Авлигын талаар гомдол, мэдээлэл өгөх
Хууль ёсыг чандлан сахидаг орчин нөхцөл бий болго. Хуулийн байгууллагууд зөрчил маргааныг шударгаар, хууль ёсны дагуу шийдвэрлэж чадна гэдэгт итгэлтэй байгаа цагт иргэд, бизнес эрхлэгчид зохион байгуулалттай гэмт хэрэг, хар тамхи, хүний наймаа болон терроризмын нөлөөллийг хязгаарлахад хувь нэмэр оруулж чадна.

Боловсролыг дэмжих...

Боловсролд хөрөнгө оруулах, боловсролын санхүүжилтийг хамгаалах
Иргэдүйн хөгжил цэцэглэлт нь боловсролын үйл ажиллагаа болон түүний чанараас шууд хамаарна. Боловсролын салбарын төсөв, хөрөнгийг шударга, ил тод зарцуулснаар улс орны хамгийн үнэт зүйл болох үр хүүхдүүдээ хамгаалах болно.

Хөгжил цэцэглэлтийг авчрах

Хууль бус, ил тод бус бүхий л арга хэмжээнд оролцохоостатгалзах
Хөрөнгө мөнгө авлигач албан хаагчдын халаасанд орохгүй юм байна гэдгийг олж мэдсэн цагт хөрөнгө оруулах сонирхол нэмэгдэж, дотоод болон гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгддэг.

Хөгжлийг хамгаалах...

Авлигын Эсрэг НҮБ-ын Конвенцийн дагуу төр засаг болон төрийн албан хаагчдад ямар шаардлага тавигддагыг олж мэдэх
Авлига, хээл хахуулийг бууруулснаар том, жижиг, бүх компанийд бизнесээ тогтвортой явуулах боломж нэмэгдэх бөгөөд нийгэм, эдийн засгийн хөгжлийг бий болгодог.

Нийгмийн эрүүл мэндийг сайжруулах...

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хөрөнгө санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулах
Хүн амын эрүүл мэнд, амь насыг авардаг учраас үр ашигтай, хүртээмжтэй эрүүл мэндийн үйл ажиллагаа нь иргэдэд хүрэх хамгийн чухал үйлчилгээний нэг юм.

ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА, ИРГЭНИЙ НИЙГМИЙН БАЙГУУЛЛАГУУД дараах байдлаар авлигатай тэмцэх боломжтой

Ардчиллыг бэхжүүлэх...

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хөрөнгө санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулах
Хүн амын эрүүл мэнд, амь насыг авардаг учраас үр ашигтай, хүртээмжтэй эрүүл мэндийн үйл ажиллагаа нь иргэдэд хүрэх хамгийн чухал үйлчилгээний нэг юм.

Шударга ёсыг бэхжүүлэх

Төр засаг авлигагүй байх үүрэг, хариуцлага хүлээдгийг олон нийтэд таниулан ойлгуулах
Эрх тэгш ба шударга ёс нь улс орны тогтвортой байдал болон хөгжлийн үндэс суурь бөгөөд гэмт хэрэгтэй тэмцэхэд чухал үүрэг гүйцэтгэнэ.

Боловсролыг дэмжих...

Ёс зүй, авлига, хээл хахууль гэж юу болох, түүнтэй хэрхэн тэмцэх, боловсрол авах эрхээ шаардах талаар хүүхэд залуучуудад мэдлэг олгох
Гэрэл гэгээтэй ирээдүйг бий болгох шилдэг арга зам бол авлига, хээл хахуулгүй нийгмийг хүсч хүлээсэн хойч ге болон хүүхэд залуучуудыг бэлдэх явдал юм.

Хөгжил цэцэглэлтийг авчрах...

Адил тэгш орчин нөхцөл нь улс орны хөгжилд эерэгээр нөлөөлнө гэдгийг иргэний нийгмийн хамтрагчид, хувийн хэвшил, төр засгийн байгууллага, олон нийтэд хэлж ойлгуулах
Бизнесийн орчин нээлттэй, ил тод байх тусам үндэсний болон олон улсын хөрөнгө оруулалт нэмэгдэнэ.

Хөгжлийг хамгаалах...

Шударга өрсөлдөөний дүрэм жүрмыг хэрэгжүүлэх
Авлига, хээл хахууль нь нэр хүндгүй компаниуд шударга бус өрсөлдөх боломжийг олгодог бөгөөд үр ашигтүй компаниуд оршин тогтсоор байх, улмаар зах зээлийг гажуудуулах аюултай.

Нийгмийн эрүүл мэндийг сайжруулах...

Эрүүл мэндийн салбар дахь авлигын өртөг зардал, хор уршгийн талаарх ойлголт мэдлэгийг олон нийт, хэвлэл мэдээлэл болон төр засгийн байгууллагуудад өгөх
Үр ашигтай, хүртээмжтэй эрүүл мэндийн үйлчилгээ нийгэмд бүхэлд нь сайн нөлөөтэй.

ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН БАЙГУУЛЛАГУУД дараах байдлаар авлигатай тэмцэх боломжтой

Ардчиллыг бэхжүүлэх...

Авлигын Эсрэг НҮБ-ын Конвенцид нэгдэн орох, хэрэгжүүлэх эсвэл үчирч бүй саад бэрхшээлийн талаар мэдээлэх
Төр засгийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналт тавих нь төрийн байгууллагууд зөв зохистой үйл ажиллагаа явуулах нэг арга.

Шударга ёсыг бэхжүүлэх...

Интернэтийн боломжуудыг ашиглан авлига, хээл хахуулийг мэдээлсэн сэтгүүлч болон бусад шүгэл үлээгчийг хамгаалах
Интернэт, олон нийтийн сүлжээ, үхаалаг утас нь бага зардлаар, маш олон хүнд богино хугацаанд мэдээлэл хүргэх, улмаар авлигын талаар мэдээлэгчийг олон нийтийн анхаарал, хамгаалалтад оруулах боломжийг бий болгоно.

Боловсролыг дэмжих...

Боловсролын салбарын төрийн бус байгууллагуудтай хамтран, асуудлыг олон нийтэд мэдээлэх
Төрийн бус болон хэвлэл мэдээллийн байгууллагууд хамтран боловсролын салбарын төсөл хөтөлбөрүүд нээлттэй, ил тод байгаа эсэх, хөрөнгө санхүүжилт зориулалтын дагуу зарцуулагдаж байгаад хараа хяналт тавих боломжтой.

Хөгжил цэцэглэлтийг авчрах...

Хувийн хэвшил хамтран бизнесийн үйл ажиллагааны талаар мэдээллэх
Компанийн үнэ цэнийн нэг хэсэг нь хэрэглэгчдээсээ олж авсан нэр хүнд байдаг. Авлига, хээл хахууль холбогдсон талаарх болон авлигаас ангид байгаа сайн туршлагыг мэдээлж байх нь бизнесийн байгууллагууд хууль дүрэм, олон улсын сайн жишгийн дагуу үйл ажиллагаа явуулахад нь тулгэц болдог.

Хөгжлийг хамгаалах...

Нийтийн ашиг сонирхлын төлөө мэргэжлийн түвшинд мэдээлэхэд сураалцах, хараат бус сэтгүүлчдийн нэгдлийг дэмжих
Хүчтэй, эрх чөлөөтэй, мэргэжлийн хэвлэл мэдээллийн салбар нь хөгжлийн чухал үзүүлэлт юм. Үүний тулд мэргэшсэн сэтгүүл зүйн үйл ажиллагаа явуулж, хараат бус сэтгүүлчдийн эвлэл, холбоодод нэгдэх нь чухал.

Нийгмийн эрүүл мэндийг сайжруулах...

Нийгмийн эмзэг бүлэгт үзүүлж буй эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийн талаар мэдээлдэг хот, хөдөөгийн сэтгүүлчидтэй хамтран ажиллах
Орон нутаг болон үндэсний хэмжээний мэдээллийн эх сурвалжийг холбож, цуглуулан мэдээллээ олон нийтэд хүргэх нь хүчтэй арга хэрэгсэл юм.

ХУВИЙН ХЭВШЛИЙН БАЙГУУЛЛАГА, АЖ АХУЙН НЭГЖҮҮД, дараах байдлаар авлигатай тэмцэх боломжтой

Ардчиллыг бэхжүүлэх...	**Авлигыг үл тэвчих практикийг хэвшүүлэх замаар эдийн засгийн тогтвортой байдлыг дэмжих** *Нээлттэй, ил тод хувийн хэвшил бол ардчиллын нэг тулгуур хүчин зүйл юм.*
Шударга ёсыг бэхжүүлэх...	**Бэлэг сэлт, хангамж, шүгэл үлээгч гэх мэттэй холбоотой бодлого, дүрэм журам гаргаж хэрэгжүүлэх, ажилтнуудаа энэ талаарх мэдлэг, мэдээлэл олгох** *Ажилтан, албан хаагчид шударга орчин нөхцөл, хууль ёсны хүрээнд ажиллаж байгаадаа итгэлтэй үед тэд илүү үр бүтээлтэй байдаг.*
Боловсролыг дэмжих...	**Боловсролын төсөл хөтлбөрүүдийг санхүүжүүлэх, хөрөнгө оруулалт хийх, тэгш шударгаар хэрэгжиж байгаад хяналт тавих** *Боловсролын салбарт хандив, бусад дэмжлэг үзүүлэх нь ирээдүйдээ хийж буй чухал хөрөнгө оруулалт юм.*
Хөгжил цэцэглэлтийг авчрах...	**Авлигаас сэргийлэх үйл ажиллагаа хэрэгжүүлж, хараат бус аудит хийлгэх. Нийгмийн салбарын яриа хэлэлцүүлэгт Авлигын эсрэг стратегийн асуудлыг оруулах (Үйлдвэрчний эвлэл хэсийг харна уу)** *Хэвл хахууль хэлбэрээр авч буй татвар, авлигач албан тушаалтнуудтай тохиролцоо хийх менежментийн зардал, авлигын улмаас хүлээх торгууль, хуулийн хариуцлага зэрэг нь бизнесийн өртөг зардлыг ихээр нэмэгдүүлдэг.*
Хөгжлийг хамгаалах...	**Шударга өрсөлдөөний дүрэм журмыг хэрэгжүүлэх** *Авлига, хэвл хахууль нь нэр хүндгүй компануд шударга бус өрсөлдөх боломжийг олгодог бөгөөд үр ашигүй компануд оршин тогтсоор байх, улмаар зах зээлийг гажуудуулах аюултай.*
Нийгмийн эрүүл мэндийг сайжруулах...	**Эрүүл мэндийн салбар дахь компануд үйл ажиллагаагаа олон улсын жишиг стандартад нийцүүлж байхад анхаарах** *Ашгийн төлөө хуурамч, чанаргүй эм, эмийн бүтээгдэхүүн зах зээлд нийлүүлэх нь иргэд, нийгмийн бүх гишүүдэд аюул учруулдаг. Тиймээс эвөхөн ашиг бодож энэ мэт зөрчилтэй эвлэрэхгүй байх.*

ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛҮҮД дараах байдлаар авлигатай тэмцэх боломжтой

Ардчиллыг бэхжүүлэх...	**Төрийн албан хаагчдад хангалттай цалин хөлс олгох талаар хэлэлцэх** *Төрийн албан хаагчид хангалттай цалин хөлс, орлоготой байх нь хэвл хахууль халааслахаас сэргийлэх чухал хүчин зүйл мөн.*
Шударга ёсыг бэхжүүлэх...	**Авлигын мэдээлэгчийг хамгаалах** *Авлигач этгээдүүдийг мэдээлж, хариуцлага тооцуулахын тулд өөрийн ажил амьдрал, амь насаа болзошгүй эрсдэлд оруулж байгаа хүмүүсийг хамгаалах ёстой. Авлигыг илрүүлж, мэдээлэх нь аюулгүй бол илүү олон хүмүүс нэмэгдэх болно.*
Боловсролыг дэмжих...	**Боловсролын тогтолцооны зөв шударга байдалд хяналт тавих** *Багш нар хүүхэд багачуудыг сурган хүмүүжүүлж, халамжлахаас гадна боловсролын тогтолцооны шударга ёс, нэр хүндийг хамгаалах ёстой хүмүүс юм*
Хөгжил цэцэглэлтийг авчрах...	**Боловсролын тогтолцооны зөв шударга байдалд хяналт тавих** *Багш нар хүүхэд багачуудыг сурган хүмүүжүүлж, халамжлахаас гадна боловсролын тогтолцооны шударга ёс, нэр хүндийг хамгаалах ёстой хүмүүс юм*
Хөгжлийг хамгаалах...	**Үйлдвэрний эвлэлүүдийн дуу хоолой, хамтын хүчийг авлигын эсрэг үйл ажиллагаанд зориулах** *Шударга, нээлттэй, ил тод нийгмийг хамтын хүчээр хамгаалах нь хөжлийг дэмжихийн зэрэгцээ ядуурлыг бууруулна.*
Нийгмийн эрүүл мэндийг сайжруулах...	**Эрүүл мэндийн салбарын ажилчдын цалин хөлсийг нэмэгдүүлэх, ажлын орчин нөхцөл, үйлчилгээг сайжруулах** *Эрүүл мэндийн салбарын үйлдвэрчний эвлэл нь тусламж үйлчилгээ болон ажиллах орчныг сайжруулах замаар ажиллагсдын авлига, хээл хахуульд өртөх эрсдлийг бууруулж чадна. Түүнчлэн авлигыг үл тэвчих хандлагыг ажиллагсдын дунд бий болгох ёстой.*

БИД БҮГД дараах байдлаар авлигатай тэмцэх боломжтой

Ардчиллыг бэхжүүлэх...	**Хууль тогтоомжийн талаар мэдлэг мэдээлэлтэй болох, мөн төр засаг авлигатай тэмцэхийн түлд юу хийх үүрэг амлалт авсныг олж мэдэх** *Иргэд, олон нийт мэдлэгтэй байх нь эрүүл ардчиллын чухал шинж бөгөөд сонгогдсон төрийн албан хаагчид үүрэг хариуцлагаа ойлгож мэдэрч байх нөхцлийг бүрдүүлдэг.*
Шударга ёсыг бэхжүүлэх...	**Авлига, хээл хахуулийг зохих төрийн байгууллагуудад мэдээлэх** *Мэдээлэл өгч, санаачлагатай байх нь авлигын эсрэг тэмцэхээс гадна нийгэм, олон нийтийн сайн сайхны төлөө үйл хэрэг юм.*
Боловсролыг дэмжих...	**Авлига тэвчиж болшгүй зүйл гэдгийг хүүхэд багачуудад зааж сургах** *Эцэг эхчүүд ёс суртахуун, шударга ёсны талаар үр хүүхдүүдээ сурган хүмүүжүүлэх ёстой.*
Хөгжил цэцэглэлтийг авчрах...	**Хээл хахууль, авлигын зорилготой бэлэг сэлт, хөлс төлбөр авах болон өгөхөөс татгалзах** *Хийсэн буюу хийх ажлын хариуд өгч буй хууль бус төлбөр, шан харамжаас татгалзах нь тэдгээр давуу байдал олж авах хүсэлтэй хүмүүст том дохио, сануулга болдог.*
Хөгжлийг хамгаалах...	**Авлигын эсрэг үйл ажиллагаа нь хөгжлийн бүх бодлого, төлөвлөлтийн салшгүй хэсэг байх ёстойг сонгогдсон төрийн албан хаагчдад сануулж байх** *Иргэд олон нийтийн эрх ашиг, хүсэл зоригийг гадаад, дотоодод төлөөлж байх ёстой таны сонгосон улс төрч, албан тушаалтанд амлалтыг нь сануулж, шаардаж байх нь таны эрх тэдийгүй, бас үүрэг хариуцлага юм.*
Нийгмийн эрүүл мэндийг сайжруулах...	**Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний талаарх нээлттэй, ил тод байдлыг шаардах. Жишээ нь, иргэд ямар үйлчилгээ авах эрхтэй, тэдгээрийн үнэ өртөг гэх мэт** *Анхан шатны эмнэлгийн тусламж, үйлчилгээ авах нь иргэн бүрт олгогдсон эрх юм. Эрхээ мэдэж байх, зөв асуулт асуух, зүй ёсны шаардлага тавих нь хариуцлагатай иргэн байхын нэг ур чадвар юм.*

The Asia Foundation

Canada